



**GRATA**  
INTERNATIONAL

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөл

**GRATA International Mongolia**

[www.gratanet.com](http://www.gratanet.com)

## **Хүний Хувийн Мэдээлэл Хамгаалах тухай хуулийн төсөл**

1995 онд батлагдсан Хувь хүний нууцын тухай хууль нь хувь хүн нууцаа өөрөө хамгаалах, хувийн мэдээллийг өөрөө нууц гэж тодорхойлох маш ерөнхий зохицуулалттай хууль тул хурдацтай хөгжиж буй технологийн эрин үед зайлшгүй шинэчлэн батлах шаардлага бий болсон. Иймээс Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020 – 2021 оны үйл ажиллагааны хөтөлбөр” – ийн “Засаглалын бодлого” –ийн 4.1.2-т “Хүний эрхийг дээдэлсэн, цахим засаглалыг дэмжсэн, технологийн аюулгүй, зохистой харилцааг зохицуулсан хууль, эрх зүйн орчинг бүрдүүлэх”, 4.1.6-д “Үндэсний ашиг сонирхлыг хамгаалсан төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг хангасан мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоог бэхжүүлж, чадавхийг нэмэгдүүлнэ” гэж заасан. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөл батлагдах шатандаа явж байгаа бөгөөд бидний зүгээс энэхүү хуулийн төсөлд орсон шинэлэг зохицуулалтыг тоймлон уншигч танд хүргэж байна.

Хуулийн төсөл нь нийт 8 бүлэг, 29 зүйлтэй бөгөөд хуулийн зорилт нь хүний хувийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах, аюулгүй байдлыг хангахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино. Онцлог зохицуулалтын хүрээнд:

1. Энэхүү хуулиар хүний хувийн мэдээлэл, хүний эмзэг мэдээлэл, хүний хувийн мэдээлэл цуглуулах, хүний хувийн мэдээлэл боловсруулах, хүний хувийн мэдээлэл ашиглах, мэдээллийн эзэн, мэдээлэл хариуцагч, генетикийн мэдээлэл, биометрик мэдээлэл, эрүүл мэндийн мэдээлэл, цахим тодорхойлогч гэсэн нэр томъёонуудыг тодорхойлсон.
2. Мэдээлэл хариуцагч мэдээллийн эзнээс бичгэн зөвшөөрөл авсны үндсэн дээр мэдээлэл цуглуулах бөгөөд дараах нөхцөлийг танилцуулж, зөвшөөрөл авах ёстой:
  - Мэдээлэл цуглуулах үндэслэл, зорилго;
  - Мэдээлэл хариуцагчийн нэр, хуулийн этгээд бол оноосон нэр, холбоо барих мэдээлэл;
  - Боловсруулах мэдээллийн жагсаалт;
  - Мэдээлэл боловсруулах, хадгалах хугацаа;
  - Мэдээллийг ил болгох эсэх;
  - Мэдээллийг бусдад дамжуулах эсэх;
  - Зөвшөөрлөө цуцлах нөхцөл.

Мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах эрхтэй этгээдийн хувьд төрийн байгууллага, хувь хүн, хуулийн этгээд байж болно гэхдээ ямар тохиолдолд мэдээллийг цуглуулж боловсруулах талаар тодорхой зохицуулсан. Тухайлбал хуулийн этгээдийн хувьд дараах тохиолдолд мэдээлэл цуглуулж, боловсруулж,

ашиглана:

- Хуульд заасан бол;
- Хувь хүнтэй гэрээ байгуулах, байгуулсан гэрээний дагуу эрхээ эдлэх, үүргээ

биелүүлэх;

- Мэдээллийн эзэн өөрөө, эсхүл хуульд заасны дагуу нийтэд ил болгосон;
- Хувь хүнийг тодорхойлох боломжгүй болгож статистик мэдээлэл бэлтгэх болон судалгаа шинжилгээ хийх;
- Мэдээллийн эзний зөвшөөрлөөр.

Түүнчлэн хүний эмзэг мэдээлэл, биометрик мэдээлэл, түүхийн болон шинжлэх ухааны судалгаа шинжилгээ хийх, статистикийн мэдээлэл, хэвлэл мэдээллийн зорилгоор мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглахад тус бүрт нь шалгуур тавьсан.

3. Мэдээллийн эзний эрх, үүргийг тусад нь 3 дугаар бүлэгт бүхэлд нь зохицуулсан бөгөөд тухайлбал мэдээллийн эзэн өөрт хамааралтай мэдээллийг цуглуулсан, боловсруулсан, ашигласан эсэхийг мэдэх, өөрийн мэдээллийг устгуулах, эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл тухайн эрхээ хамгаалуулах, бусдын хууль бусаар учруулсан хохирол болон эдийн бус гэм хорыг арилгуулах эрхтэй гэх мэт.
4. Одоо хэрэгжиж буй хуулиар зохицуулагдаагүй мэдээлэл хариуцагч болон мэдээлэл боловсруулагчийн талаар шинэ зохицуулалт бий болсон бөгөөд тэдгээрийн хүлээх үүргийг нарийвчлан зохицуулсан. Түүнчлэн мэдээлэл хариуцагч мэдээлэл цуглуулах, боловсруулах үүргийг гэрээний үндсэн дээр мэдээлэл боловсруулагчид шилжүүлж болно. Мэдээлэл боловсруулагч мэдээлэл хариуцагчийн өгсөн үүрэг, чиглэл, даалгаврыг зөрчсөн нь мэдээлэл хариуцагчийг мэдээллийн эзний өмнө хүлээсэн үүрэг, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй. Харин мэдээлэл хариуцагч нь мэдээлэл боловсруулагчид гэрээний үндсэн дээр мэдээлэл цуглуулах, боловсруулах үүргийг шилжүүлээгүй тохиолдолд мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах үүргийг өөрөө гүйцэтгэнэ.
5. Мэдээлэл хамгаалах үйл ажиллагааны хүрээнд мэдээлэл хариуцагч болон боловсруулагч нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр зохион байгуулалтын болон техникийн арга хэмжээг хэрэгжүүлдэг. Түүнчлэн дараах тохиолдолд мэдээлэл хариуцагч мэдээллийн эзэнд мэдэгдэл өгнө:
  - Хүний эмзэг мэдээллийг ашигласан;
  - Мэдээллийн эзний зөвшөөрлөөр мэдээлэл боловсруулахаас бусад үндэслэл, зорилгоор мэдээлэл боловсруулахад мэдээллийг гуравдагч этгээдэд дамжуулсан.

Мэдээлэл боловсруулагч нь мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахад

илэрсэн зөрчлийг мэдсэн даруйд эсхүл мэдээллийн эзний эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулахаар бол мэдээллийн эзэнд даруй мэдэгдэнэ.

6. Энэхүү хуульд орсон шинэлэг зохицуулалтын нэг бол дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн систем буюу төхөөрөмжийг ашиглан мэдээлэл цуглуулах, хадгалах болон ашиглах юм. Энэхүү зохицуулалтын хүрээнд дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн төхөөрөмжийг байрлуулж болох газар болон байрлуулахыг хориглосон газрыг тус тус ангилж өгсөн. Тухайлбал: ариун цэврийн өрөө, хувцас солих өрөө, нийтийн үйлчилгээний газрын тусгай зориулалтын үйлчилгээний өрөө, караоке, зочид буудлын өрөө, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх хэвтүүлэн эмчлэх өрөөнд дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн систем буюу төхөөрөмжийг байршуулахыг хориглосон.

Дэлгэрэнгүй мэдээлэл авах эсвэл асуулт байвал GRATA Интернэшнл хуулийн фирмийн Партнер В.Болормаагийн [bvolodya@gratanet.com](mailto:bvolodya@gratanet.com) болон Хуульч Б.Янжмаагийн [ybumtsend@gratanet.com](mailto:ybumtsend@gratanet.com) хаягаар эсвэл 976 70155031 утсаар холбоо барина уу.

*Дэлхийн 20 улсад салбартай олон улсын хуулийн фирм GRATA Интернэшнлийн Монгол дахь оффис болох Өмгөөллийн “GRATA Интернэшнл Монголиа” ХХН энэхүү хууль зүйн мэдээллийг бэлтгэсэн. Энэхүү хуулийн зүйн мэдээлэл нь ерөнхий мэдээлэл өгөх зорилготой бөгөөд тодорхой асуудалд нарийвчлан дүн шинжилгээ хийгээгүй болно. Энэхүү хууль зүйн мэдээллийг уншигч нь ямар нэгэн үйлдэл хийхээсээ өмнө өөрсдийн нөхцөл байдалд тохирсон мэргэжлийн зөвлөгөө авах хэрэгтэй. Энэхүү хууль зүйн мэдээллийг ашигласны улмаас үүссэн аливаа үр дагавар, хохирлыг бид хариуцахгүй.*